

ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГЫН ЗАРИМ АСУУДАЛД

П.Лхамсүрэн¹

Удиртгал

Сүүлийн жилүүдэд улс орнуудын эдийн засгууд ойртон нягтарч, глобальчлал, эдийн засгийн интеграцчилал дэлхий нийтийг хамарч байна. Гадаад худалдааг либералчилах, худалдаан дахь саад тотгорыг арилгах, худалдаагаар дамжин эдийн засгийн өсөлтийг бий болгох хандлага олон улсын худалдааны бодлогод зонхилох байр эзэлж байгаа ба худалдааны нийтлэг бодлого тодорхойлдог дэлхийн хэмжээний байгууллага болох Дэлхийн Худалдааны Байгууллагын (цаашид ДХБ) үндсэн зорилт үүнтэй уялдаж тодорхойлогдсон байдаг.

Худалдааны бодлогын эрх зүйн орчны талаар: Монгол улсын худалдааны бодлого нь тус улсын нэгдэн орсон олон талт гэрээ хэлэлцээр болон хоёр талын гэрээ, дотоодын хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм журмын хүрээнд тодорхойлогдож байдаг.

Монгол улсад өрнөсөн ардчилсан өөрчлөлтийн нөлөөгөөр 1990-ээд оноос гадаад худалдааны бодлогоо цоо шинээр тодорхойлох шаардлагатай тулгарсан. Ингэснээр уламжлалт худалдааны харилцаатай улсуудтай худалдааны харилцаагаа цаашид харилцан ашигтай үргэлжлүүлэх, шинээр бусад улсуудтай худалдаа хийх шаардлагатай болсон. 1990 онд БНМАУ-ын засгийн газар, БНАЛАУ-ын засгийн газар хоорондын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр, 1991 онд БНМАУ-ын засгийн газар, ЗСБНХОУ-ын засгийн газар хоорондын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр, 1992 онд МУ-ын засгийн газар, БН Казакстан улсын засгийн газар хоорондын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр, МУ-ын засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь улсын засгийн газар хоорондын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийг байгуулж харилцан худалдааны нэн тааламжтай нөхцөл олгох талаар тохиролцож байсан.

1997 онд ДХБ-д элсэн орсон бөгөөд худалдаагаа илүү чөлөөтэй илүү нээлттэй болгож олон талт гэрээгээр хүлээсэн үүрэг амлалтаар гаалийн тарифын хэмжээг 20 хувиар тогтоохоор тохиролцсон боловч одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа гаалийн тарифын тухай Монгол улсын хуулиар нэн тааламжтай тариф 5 хувь байна. Нэн тааламжтай тарифыг хэрэглэх улсын жагсаалтыг баталсан МУ-ын засгийн газрын 2009 оны 87 тоот тогтоолоор ДХБ-ын гишүүн 152 улс, ОХУ, Лаос, Беларусь, Казахстан зэрэг худалдаа эдийн засгийн хоёр талын хэлэлцээр байгуулсан 4 улс, нийт 156 улсын гаралтай бараа бүтээгдэхүүнд хамрагдахыг заажээ. Тарифын бус арга хэмжээг БТКУС-ын 9-р бүлэгт хамаарах бараанд л хэрэглэх талаар УИХ-ын 1998 оны 51 тоот тогтоолд заасан байна. Экспортын тарифын хувьд ДХБ-д нэгдэн орох асуудлаар ажлын

¹ МУИС-ийн ОУХС-ийн багш, докторант

хэсгийн илтгэлд дурьдсанаар боловсруулаагүй ноолуурын экспортын татварыг үнийн дүнгийн 30 хувиас хэтрүүлэхгүй бөгөөд нэгдэн орсноос 10 жилд зохих шатлалаар бууруулж улмаар хална гэсэн үүрэг амлалт авсан байна. Одоогоор 2012 он хүртэл энэ татварыг хэвээр үлдээх зөвшөөрөл аваад байна. Бусад барааны хувьд экспортын гаалийн татвар байхгүй.

Худалдааны бодлогын өөрчлөлт: 1990-ээд оны эхэн үед Монгол улс худалдааны уламжлалт харилцаатай улсууд болон хуучин ЗХУ, түүний бүрэлдэхүүнд байсан улсуудтай цаашид шинэ нөхцөл байдалд хамтран ажиллах, олон улсын эдийн засгийн интеграцид нэгдэх зорилт тавьж ихээхэн чармайлт тавьж байсан. Энэ үед МУ-ын төр засгийн зорилго нь гадаад худалдаагаа либералчилахад голчлон анхаарч, дотоодын эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэгдсэн зохистой худалдааны бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд төдийлөн анхаарал хандуулаагүй мэт харагддаг. Тухайлбал, 1996-2000 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөрт: ДХБ-д элсэхтэй холбогдсон гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүрэг, амлалтуудыг хугацаанд нь биелүүлж, гадаад худалдааг олон улсын жишигт нийцүүлэн чөлөөтэй болгох бодлогыг тууштай явуулна гэж заасан байгаа. 1997 онд ДХБ-д элсэхдээ гаалийн татварын талаар хүлээсэн хувь хэмжээнээс бодит хэрэглэж байгаа тариф хэд дахин бага төдийгүй зарим үед тэглэж байсан тохиолдол ч байсан. Мөн ДХБ-аас зөвшөөрөгдсөн худалдааг хамгаалах арга хэмжээ болох онцгой үеийн худалдааны хориг, шударга бус өрсөлдөөнийг хориглох зэрэг арга хэмжээг огт хэрэглээгүй юм.


Харин 2000 оноос гадаад худалдаанд төрөөс баримтлах үндсэн бодлогын баримт бичгүүдэд зарчмын өөрчлөлт гарч эхэлсэн бөгөөд дараах зүйлсийг тусгасан байна.

- МУ-ын гадаад бодлогын хөх номд (УБ 2000 он): “Худалдааг либералчилах дэлхийн нийтлэг хандлага, бодлогыг Монгол улс гишүүний хувьд дэмжиж... ДХБ-ын шийдвэрүүд, худалдааны олон талт хэлэлцээрүүдийн дагуу хөгжиж буй орнуудад олгож буй хөнгөлөлттэй нөхцөл, болзлыг ашиглах эрхээ бүрэн эдлэхийг эрмэлзэж байна” гэж заасан.
- МУ-ын засгийн газрын 2000-2004 оны үйл ажиллагааны хөтөлбөрт: “... Гадаад худалдааг алдагдалгүй болгох зорилтыг хэрэгжүүлнэ. Экспортод бүтээгдэхүүнээ гаргадаг үйлдвэрүүдэд тоног төхөөрөмж, түүхий материал импортлоход нь дэмжлэг үзүүлэхээс гадна “Ноолуур”, “Мах” зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж экспортын үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх зорилт тавьсан.
- МУ-ын засгийн газрын 2004-2008 оны үйл ажиллагааны хөтөлбөрт: “... Импортын татварын болон дотоодын зах зээлийг хямралаас урьдчилан сэргийлэх, хамгаалах зохистой бодлого баримтлана” гэж заасан.
- МУ-ын засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт: Экспортын чиглэлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ давамгайлсан, хувийн хэвшилд суурилсан эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх, экспортын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд татварын болон урамшууллын бодлогоор дэмжлэг үзүүлнэ.
- МУ-ын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай 2010 оны 48-р тогтоолын хавсралтад: “... Гадаад худалдааны алдагдлыг багасгаж, тарифын болон тарифын бус арга хэрэгслийг дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор зохистой хэрэглэнэ” гэж тодорхойлсон.

Худалдааны либерал бодлогыг өнөөг хүртэл тууштай хэрэгжүүлж байгаа боловч энэ нь манай улсын эдийн засаг, гадаад худалдаанд хэрхэн нөлөөлж байгааг авч үзье.

Гаалийн мэдээ баримтаас үзэхэд Монгол улс 2009 оны байдлаар дэлхийн 59 улстай экспорт, импортын, 26 улстай импортын, 15 улстай экспортын, нийт 90 улстай худалдааны харилцаатай байна. Сүүлийн 15 жилийн дунджаар тооцож үзэхэд Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн улсуудтай хийсэн худалдаа 75,28 хувь, хоёр талын худалдааны гэрээгээр харилцан нэн тааламжтай нөхцөл олгодог ОХУ, Беларусь, Казакстан, Лаос улсуудтай хийсэн худалдаа 23,89 хувь, үлдсэн 1 хүрэхгүй хувь нь ердийн нөхцлөөр худалдаа хийдэг улсуудтай худалдааны харилцаатай явж иржээ.

Гадаад худалдааны нийт эргэлтэд улс орнуудын эзлэх хувь




Эх үүсвэр: МУ-ын статистикийн эмхэтгэл

Мөн хугацаанд импортын 62,2 хувь нь ДХБ-ын гишүүн улсууд, 37,2 хувь нь 2 талын гэрээгээр худалдааны нэн тааламжтай нөхцөл олгодог дээрх 4 улс, 0,6 хувь нь ердийн нөхцлөөр худалдаа хийдэг бусад улсад ноогдож байна.

Монгол Улсын гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4.2-т зааснаар импортын гаалийн тарифыг ердийн болон нэн тааламжтай гэж ангилах ба ердийн тариф нь нэн тааламжтай тарифаас хоёр дахин их хэмжээтэй байдаг. Импорт бараг бүхлээрээ нэн тааламжтай тарифтай буюу 5 хувийн татвартай байна.

Гадаад худалдааны тэнцэл



Эх үүсвэр: МУ-ын статистикийн эмхэтгэл

1997 оноос хойш 2006 оныг эс тооцвол худалдаа үргэлж алдагдалтай явж ирсэн байна. Гэвч энэ нь дотоодын үйлдвэрлэлийн өсөлттэй холбоотой гэхээсээ дэлхийн зах зээл дээрх зарим бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой юм.

Эндээс үзэхэд чөлөөт худалдааны бодлогын МУ-ын эдийн засагт үзүүлж байгаа эерэг нөлөө төдийлөн харагдахгүй байна. Түүнчлэн гадаад худалдааны талаар төрөөс баримтлах бодлого, бодит байдал дээр хэрэгжихгүй байна гэж дүгнэж болохоор байна.

Дүгнэлт

- Худалдааны бодлогыг хэрэгжүүлэх нь нарийн төвөгтэй асуудал байдаг. Улс орнууд хөгжлийн төвшин, дотоодын үйлдвэрлэл, улс төрийн бодлогын чиг хандлага гэх мэт олон хүчин зүйлийн нөлөөгөөр худалдааны бодлогоо тодорхойлж байна. Туйлын оновчтой бодлогыг тодорхойлох боломж одоогоор алга байгаа.
- Чөлөөт худалдааны бодлогыг дэмжигчидийн жишээ авдаг хөгжингүй орнуудад энэ бодлогын үзүүлж байгаа нөлөөлөлд болгоомжтой хандах шаардлагатай мэт. Учир нь эдгээр орнууд хэзээ нэг цагт хамгаалалттай худалдааны бодлогыг хэрэгжүүлж байснаас гадна одоо ч зарим салбар нь хангалттай хамгаалагдсан байдаг. Тухайлбал АНУ, Япон, ЕХ-ны худалдааны бодлого хоёрдмол шинжтэй, өндөр хөгжсөн салбаруудад нь чөлөөт худалдааны бодлого ашигтай байдаг бол уламжлалт болон ХАА-н салбаруудаа хамгаалах арга хэмжээг хангалттай авсаар байна.
- Худалдааны ямар бодлого баримталж байгаа нь ихэнхдээ дотоодын эдийн засгийн хөгжилтэй холбоотой байна. Ихэнх улсууд хөгжлийн эхэн үедээ дотоодын үйлдвэрлэлээ хамгаалах сонирхолтой байдаг бол хөгжингүй улсууд дэлхийн зах зээлийн боломжийг ашиглах боломжтой чөлөөт худалдааны бодлогыг илүүтэй дэмждэг байна.
- Төр засгийн бодлогод тусгагдсан, олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгт харшлахгүй тарифын болон тарифын бус арга хэрэгслүүдийг практикт ашиглаж, тэдгээр арга хэрэгслүүдийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжихээс гадна импортыг орлуулах үйлдвэрлэлийн салбаруудыг оновчтой тодорхойлж тэдгээр салбаруудыг дэмжих бодлого хэрэгжүүлэх нь зайлшгүй юм. Эцэст нь дүгнэхэд худалдааны бодлого, гадаад худалдаа, макро эдийн засгийн харилцан хамаарлын судалгааг цаашид гүнзгийрүүлэх шаардлагатай байна.

Ашигласан материал

- МУ-ын Гадаад Харилцааны Яам, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр: МУ-ын худалдааны бодлого ба хүний хөгжил. Улаанбаатар 2008 он.
- МУ-ын гадаад бодлогын хөх ном. Улаанбаатар 2000 он.
- МУ-ын ЗГ-ын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр.
- Статистикийн эмхэтгэл 1995-2009.
- МУ-ын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Улаанбаатар 2010 он.
- Олон улсын гэрээ хэлэлцээрийн эмхэтгэл. Улаанбаатар 2008 он.